ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өмнөговь корпораци” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.03.15 № 260

танай _____-ны №_____-т

"ӨМНӨГОВЬ КОРПОРАЦИ"
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар тухайн жилийн зорилтод түвшний гүйцэтгэлийг хангаагүй, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, өр төлбөр үүсгэсэн, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, худалдан авах ажиллагаанд нэмэлт гэрээ байгуулсан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн хөрөнгөөр хандив, тусламж үзүүлсэн, шатахуун зарцуулалтын тайланг үнэн зөв үйлдээгүй 326.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.6, 25 дугаар зүйлийн 25.10, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 13.3.2, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 19 дүгээр зүйлийн 19.2, 20 дугаар зүйлийн 20.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, "Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын дүрмийн 4.3, 6.13, аймгийн Засаг даргатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 3.4.1, 3.4.2-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн толилуулга, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

016020493

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/0/8 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн Хөгжил, хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын оноосон нэрийг “Өмнөговь корпораци” гэж өөрчилж, дүрмийг шинэчлэн батлсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын Тамгын газраас шилжүүлсэн 1,282.4 сая төгрөгийг Шинэ сэргэлтийн бодлого, Нээлттэй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан "Инвест говь-2023 хөрөнгө оруулалтын чуулган", төрийн албан хаагчдын сургалт, аймгийн баяр наадмын арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан нь тус газрын чиг үүрэг хамаарахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Иргэдийн оролцоо, санал санаачилгад тулгуурласан “Цэгцтэй гэр хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг Аймгийн Засаг даргын ангилагдаагүй бусад нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,329,064,027.28	1,497,650,286.99
4	Дансны авлага	64,015,338.50	40,397,394.50
8	Бараа материал	41,003,582.07	456,798,549.38
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	56,646,123.36	56,646,123.36
10	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
12		-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,490,729,071.21	2,051,492,354.23
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө барилга	1,691,466,271.00	4,039,810,708.21
23	Биет бус хөрөнгө	1,726,791,562.24	1,830,226,395.58
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,418,257,833.24	5,870,037,103.79
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,908,986,904.45	7,921,529,458.02
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
27	Өр төлбөр	-	-
31	Татварын өр	118,420,178.21	172,020,527.27
36	Урьдчилж орсон орлого	8,202,000.00	2,569,711,776.04
37	Нөөц(өр төлбөр)	-	-
38	Бусад богино хугацаат өр төлбөр	57,240.00	43,228,038.22
40		-	-
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	126,679,418.21	2,784,960,341.53
46	Бусад урт хугацаат өглөг	818,837,460.35	818,837,460.35
47		-	-
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	818,837,460.35	818,837,460.35
49	Өр төлбөрийн нийт дүн	945,516,878.56	3,603,797,801.88
50	Эздийн өмч	-	-
51	Өмч: а) төрийн	106,230,485.61	106,230,485.61
58	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,640,179,985.00	2,640,179,985.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,217,059,555.28	1,571,321,185.53
60		-	-
61	Эздийн өмчийн дүн	3,963,470,025.89	4,317,731,656.14
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,908,986,904.45	7,921,529,458.02

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,674,855,796.57	3,101,586,913.32
2	Борлуулалтын өртөг	186,681,080.52	735,879,592.36
3	Нийт ашиг	8,488,174,716.05	2,365,707,320.96
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	11,764,245.39
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	132,926,289.08	1,929,499,126.03
9	Борлуулалт, маркетингийн зардал	22,732,774.97	289,749,996.78
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,250,382,462.23	1,171,757,837.41
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	75,137,882.00	2,440,334,900.11
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	272,847,885.93	393,363,712.69
19	Орлогын татварын зардал	27,428,472.84	39,102,082.44
20	Татвар дараах ашиг (алдагдал)	27,428,472.84	354,261,630.25
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	245,419,413.09	354,261,630.25
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцааны ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,746,410,470.61	-	1,217,059,555.28	3,963,470,025.89
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	354,261,630.25	354,261,630.25
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2023 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	2,746,410,470.61	-	1,571,321,185.53	4,317,731,656.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	9,629,175,237.49	5,663,335,467.09
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,222,284,633.48	3,617,839,263.00
6	Буцаан авсан албан татвар	-	-
7	Татаас санхүүжилтийн орлого	-	-
8	Бусад мөнгөн орлого	8,406,890,604.01	2,045,496,204.09
9	Мөнгөн зарлагын дүн (-)	9,393,848,564.14	5,351,322,156.57
10	Ажиллагчдад төлсөн	333,470,677.04	502,866,603.14
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	78,366,347.59	159,019,228.37
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	6,305,263,508.88	160,378,370.93
13	Ашиглалтын зардалд төлсөн	-	13,055,940.45
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,823,800.00	56,827,150.00
15	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
16	Татварын байгууллагад төлсөн	506,888,062.90	322,558,421.75
17	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
18	Бусад мөнгөн зарлага	2,147,036,167.73	4,136,616,441.93
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	235,326,673.35	312,013,310.52
30	Мөнгөн зарлагын дүн (-)	136,575,089.64	143,427,050.00
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	136,575,089.64	143,427,050.00
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
34	Бусад урт хугацаат хөрөнгө ол эзэмшихэд төлсөн	-	-
35	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
36		-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-136,575,089.64	-143,427,050.00
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	98,751,583.71	168,586,259.71
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,230,312,443.57	1,329,064,027.28
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,329,064,027.28	1,497,650,286.99

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны зорилтод түвшний		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Орлогын эх үүсвэр	**3,238.20**	**5,532.50**	**2,294.30**	**170.85**
Борлуулалтын орлого	2,322.90	3,394.90	1,072.00	146.15
Бусад орлого	915.30	2,137.60	1,222.30	233.54
Нийт зардал	**3,128.10**	**5,139.10**	**2,011.00**	**164.29**
Урсгал зардал	1,081.50	1,238.10	156.60	114.48
Төсөл хөтөлбөр	2,046.50	1,423.30	(623.20)	69.55
Төлөвлөгөөнд тусгагдаагүй нэмэлт ажил		2,477.80	2,477.80	
Татвар төлөхийн өмнөх ашиг	**110.10**	**393.40**	**283.30**	**357.31**
Орлогын татвар хураамж	11.01	39.10	28.09	355.13
Цэвэр ашиг	**99.09**	**354.30**	**255.21**	**357.55**

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,713.4 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 12,713.4 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн орлого, зарлагын дүнг 9,478.4 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд эзэмшигчдийн өмчийн бусад хэсэгт 2,640.2 сая төгрөгийг тайлагнаагүй,
- Цагаан хад суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 10КВ болон 0,4КВ-ын өргөтгөл хийх зураг төсөв 35.6 сая төгрөг, Өмнөговь аймгийн хэмжээнд Угийн бичиг сурталчлах, хөтлөх ажлын лавлагаа 170.0 сая төгрөгийн өртөгтэй 3000 ширхэг ном, Морин заг суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил 44.5 сая төгрөгийн ажлыг тус тус хөрөнгөд бүртгээгүй
- Тайлант онд гүйцэтгэж дуусаагүй 344.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон "Цагаан хад суурьшлын бүсэд бохирын цэгийн байгууламж хийх ажил"-ыг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн толилуулга, ангилал, оршин байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 326.4 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 4.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 222.4 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 99.8 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- Шатахууны зарцуулалтын тайланг давтан шалгахад завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шаардах хуудас бичээгүй, жолоочийн тооцоонд тусгаагүй 3.1 сая төгрөгийн шатахууныг зардлаар тайлагнаж, орон нутгийн өмчийн хөрөнгийг дутагдуулсан байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 *"дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"*, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны Б/33, А/61 тоот тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг үндэслэн буцалтгүй тусламж 1 албан хаагчид, түлээ, нүүрсний хөнгөлөлт 26 албан хаагчид тус тус олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 "*Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй"*-д заасантай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

- Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гэрээний орлого, зарлага, хөрөнгө оруулалтын зорилтод түвшнийг батлуулахдаа, зураг төсөв, ТЭЗҮ, нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслээгүй, хөрөнгө оруулалтын зардлыг урсгал зардалд төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, зорилтод түвшний гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "*Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно*", 19 дүгээр зүйлийн 19.2-д "*эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин",* 20 дугаар зүйлийн 20.3-д "*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн хүрээнд дээвэр, дулаалгыг төсөл, арга хэмжээнд 58 өрхөд нийт 139.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон, Цагаан хад суурьшлын бүсэд "Бохирын цэгийн байгууламж хийх ажил"-д нэмэлт гэрээ байгуулж 44.9 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д "*хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх"*, 13.3.2-д "*хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- Тайлант хугацаанд шууд гэрээ байгуулан Номгон сумын Ерөнхий боловсролын сургуульд 20.0 сая төгрөгийн чөлөөт бөхийн дэвжээ, Даланзадгад сумын 4-р сургуульд 18.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д "*Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "*Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тус компани нь 2023 оны санхүүгийн тайлангаа 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 25 тоот албан бичгээр 02 дугаар сарын 20-ны өдөр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д *"Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 1: Төрийн өмчит хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх

Илрүүлэлт 2: Үйлдвэрлэл технологийн паркийн цэвэр усны шугамын байгууламж, худаг, шилэн кабель зэрэг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 2,149.4 сая төгрөгийн орон нутгийн өмчийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 *"эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө",* 16 дугаар зүйлийн 16.1 *"өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах",* санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 2: Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийг нэмэгдүүлж ажиллах

Илрүүлэлт 3: Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийг байгуулаагүй байна.

Энэ нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/08 дугаар тогтоолоор баталсан "Өмнөговь корпораци" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.13 "*Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын зөвлөлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлаас томилно"*-д гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 3: Дүрэмд заасны дагуу хяналтын зөвлөл байгуулах талаар эрх бүхий байгууллагад уламжлан, зөвлөлд ажлаа тайлагнаж ажиллах

Илрүүлэлт 4: Аймгийн Засаг даргын Тамгын газраас шилжүүлсэн 1,282.4 сая төгрөгийг Шинэ сэргэлтийн бодлого, Нээлттэй Өмнөговь хөтөлбөр,"Инвест говь-2023 хөрөнгө оруулалтын чуулган", төрийн албан хаагчдын сургалт, аймгийн баяр наадмын арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан нь тус газрын чиг үүрэг хамаарахгүй байна.

Энэ нь Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын дүрмийн 4.3 "Үйлдвэрийн газар нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 4: Чиг үүрэгт хамаарахгүй ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхгүй байх

Илрүүлэлт 5: Цалингийн зардлаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 16.3 сая төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлээгүй, татварт өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 5: Төсвийг зохистой удирдах, хувь хүний орлогын албан татварыг тухай бүр төвлөрүүлж ажиллах, зөрчлийг арилгах

Илрүүлэлт 6: Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Хашаандаа сайхан амьдаръя" экспод зориулж бүүт ажлын гэрээг "Глобал -Ивэнт ХХК-тай байгуулж, төлбөрт 20.9 сая төгрөг, Мэргэн түүчээ НҮТББ тай чип дулаалга-мониторинг хийлгэх гэрээний байгуулж 17.9 сая төгрөгийг тус тус олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.*1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 14/08 дугаар тогтоолоор батлсан "Өмнөговь корпораци ОНӨААТҮГ-ын дүрэм"-ын 4.3.4 "*Судалгаа, сургалтын үйл ажиллагааг явуулах*"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 6: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг өөрийн нөөц бололцоонд тулгуурлаж хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгах

Илрүүлэлт 7: Тайлант онд худалдан авах барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, шууд гэрээ байгуулж 44.6 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэгүй байна: Цалингийн зардлаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 16.3 сая төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлээгүй, татварт өглөг үүсгэж ажилласан байна.

Өгсөн зөвлөмж 7: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, зөрчлийг арилгаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн орлого, зарлагын дүнг 9,478.4 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.	1	9,478.4			1	9,478.4	1	9,478.4				
Санхүүгийн байдлын тайланд эзэмшигчдийн өмчийн бусад хэсэгт 2,640.2 сая төгрөгийг тайлагнаагүй байна.	1	2,640.2	1	2,640.2			1	2,640.2				
Цагаан хад суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 10КВ болон 0,4КВ-ын өргөтгөл хийх зураг төсөв 35.6 сая төгрөг, Өмнөговь аймгийн хэмжээнд Угийн бичиг сурталчлах, хөтлөх ажлын лавлагаа 170.0 сая төгрөгийн өртөгтэй 3000 ширхэг ном, Морин заг суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил 44.5 сая төгрөгийн ажлыг тус тус хөрөнгөд бүртгээгүй байна.	1	250.1	1	250.1			1	250.1				
Тайлант онд гүйцэтгэж дуусаагүй 344.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон "Цагаан хад суурьшлын бүсэд бохирын цэгийн байгууламж хийх ажил"-ыг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй байна	1	344.7	1	344.7			1	344.7				
Дүн	**4**	**12,713.4**	**3**	**3,235.0**	**1**	**9,478.4**	**1**	**12,713.4**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтын тайланг давтан шалгахад завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шаардах хуудас бичээгүй, жолоочийн тооцоонд тусгаагүй 3.1 сая төгрөгийн шатахууныг зардлаар тайлагнаж, орон нутгийн өмчийн хөрөнгийг дутагдуулсан байна.	1	3.1	1	3.1								
ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны Б/33, А/61 тоот тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг үндэслэн буцалтгүй тусламж 1 албан хаагчид, түлээ, нүүрсний хөнгөлөлт 26 албан хаагчид тус тус олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.	1	1.1	1	1.1								
Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гэрээний орлого, зарлага, хөрөнгө оруулалтын зорилтод түвшнийг батлуулахдаа, зураг төсөв, ТЭЗҮ, нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслээгүй, хөрөнгө оруулалтын зардлыг урсгал зардалд төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, зорилтод түвшний гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй байна.	1	0			1	0						
Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн хүрээнд дээвэр, дулаалгыг төсөл, арга хэмжээнд 58 өрхөд нийт 139.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон, Цагаан хад суурьшлын бүсэд "Бохирын цэгийн байгууламж хийх ажил“-д нэмэлт гэрээ байгуулж 44.9 сая төгрөг олгосон байна.	1	183.9			1	183.9						

Тайлант хугацаанд шууд гэрээ байгуулан Номгон сумын Ерөнхий боловсролын сургуульд 20.0 сая төгрөгийн чөлөөт бөхийн дэвжээ, Даланзадгад сумын 4-р сургуульд 18.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.	1	38.5			1	38.5						
Тус компани нь 2023 оны санхүүгийн тайлангаа 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 25 тоот албан бичгээр 02 дугаар сарын 20-ны өдөр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна	1	0					1	0				
Үйлдвэрлэл технологийн паркийн цэвэр усны шугамын байгууламж, худаг, шилэн кабель зэрэг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 2,149.4 сая төгрөгийн орон нутгийн өмчийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.	1	0					1	0				
Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийг байгуулаагүй байна.	1	0					1	0				
Аймгийн Засаг даргын Тамгын газраас шилжүүлсэн 1,282.4 сая төгрөгийг Шинэ сэргэлтийн бодлого, Нээлттэй Өмнөговь хөтөлбөр,"Инвест говь-2023 хөрөнгө оруулалтын чуулган", төрийн албан хаагчдын сургалт, аймгийн баяр наадмын арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан нь тус газрын чиг үүрэг хамаарахгүй байна.	1	0					1	0				
Цалингийн зардлаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 16.3 сая төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлээгүй, татварт өглөг үүсгэж ажилласан байна.	1	16.3					1	16.3				

Цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Хашаандаа сайхан амьдарья" экспод зориулж бүүт ажлын гэрээг "Глобал -Ивэнт ХХК-тай байгуулж, төлбөрт 20.9 сая төгрөг, Мэргэн түүчээ НҮТББ тай чип дулаалга-мониторинг хийлгэх гэрээний байгуулж 18.0 сая төгрөгийг тус тус олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	38.9					1	38.9				
Тайлант онд худалдан авах барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, шууд гэрээ байгуулж 44.6 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авсан байна.	1	44.6					1	44.6				
Дүн	**12**	**326.4**	**2**	**4.2**	**3**	**222.4**	**7**	**99.8**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын баталсан төсөв, дараа жилийн зорилтот түвшин, тайлант оны зорилтод түвшний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 286,790,175 төгрөгийн 4 ажил гүйлгээ, зарлагын 298,133,349.80 төгрөгийн 4 ажил гүйлгээ, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан тендерийн ерөнхий мэдээлэл, гэрээ хэлцэл байгуулах болон хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд тус тус байршуулаагүй байна.	1	584.9			1	584.9		
Нийт дүн	1	584.9			1	584.9		